

ХҮНИЙ ИТГЭЛ ҮНЭМШИЛТЭЙ БАЙХ ЭРХИЙН ТӨЛӨВ
БАЙДЛЫН СУДАЛГАА ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

2001-10-18

Нэг. Судалгааны ЗОРИЛГО. объект. хугацаа

1. Судалгааны баг нь хүний итгэл үнэмшилтэй байх эрх хэрхэн хангагдаж буй, ялангуяа төрийн захиргааны албан хаагчдын хувьд итгэл үнэмшилтэй байх эрхийн хэрэгжилт ямар байгаа талаар судалгаа хийж, үнэн зөв баримт, мэдээлэл олж авах, тэдгээрт анализ хийж дүгнэлт өгөхөд оршино.

2. Судалгааг Төв аймаг, Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын Газар, Санхүү, эдийн засгийн яам, Гаалийн ерөнхий газар болон тэдгээрийн төрийн захиргааны албаны салбар зөвлөлүүдийг түшиглэн явуулна.

3. Судалгааг 2001 оны 10 дугаар сарын 18-наас 31-ний хооронд багтаан явуулах бөгөөд 11 дүгээр сарын 1-нээс 10-ны хооронд анализ хийж, тайлан бичиж танилцуулна.

Хоёр. Судалгааны явцад хийж гүйцэтгэх ажил

4. Төрийн албан хаагч аливаа намын үзэл баримтлал, үзэгдэл, үзэл санаа, онол, улс төрийн урсгалд итгэл үнэмшилтэй байх талаар Монгол улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Шүүхийн тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Дипломат албаны тухай хууль, Үндсэн хуулийн цэцэгийн тухай хууль, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Улс төрийн намуудын тухай хууль болон Хүний эрхийн Түгээмэл тунхаглал, бусад олон улсын гэрээ, хэлэлцээрийн холбогдох заалтуудыг харьцуулан судална.

5. Төрийн захиргааны албан хаагчдыг эрхэлж байсан ажил албан тушаалаас нь өөрчилсөн тоо баримт материалыг 1996 оноос эхлэн шинэчилсэн судалгааг Төрийн захиргааны албаны зөвлөлөөс гаргуулан авч, зарим тодорхой баримтын талаар Төрийн захиргааны албаны зөвлөлтэй харилцан мэдээлэл солилцож, хамтарсан судалгаа явуулна.

6. Энэхүү удирдамжийн “нэг”-ийн 3-т заасан судалгааны объектуудад очиж сүүлийн 5 жилд төрийн албанаас чөлөөлөгдсөн, ажлаас халагдсан, нэр дээр нь төрийн албаны шалгалт өгч тэнцсэн боловч ажилд орж чадаагүй хүмүүсийн судалгааг гаргаж, шалтгааныг тодруулахын хамт зарим хүмүүстэй биечлэн уулзаж, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдалтай танилцана.

Мөн анкетын асуулга, сурвалжлагын аргыг хэрэглэнэ.

7. “Өдрийн сонин”, “Зууны мэдээ”, “Өнөөдөр”, “Монголын мэдээ” зэрэг сонинуудаас энэ онд төрийн албан хаагч ажлаас халагдаж, өөрчлөгдсөн тухай нийтлэл, мэдээллийг түүвэрлэн авч анализ хийх ба зарим шаардлагатай мэдээллийн мөрөөр шалгана.

Гурав.Бусад асуудал

8. Тайланд судалгаа явуулсан хугацаа, газар, байгууллага, уулзаж ярилцсан байгууллага, албан тушаалтны нэр, тоо зэрэг ажлын үзүүлэлтээс гадна судалгааны дүн, илрүүлсэн баримт жишээ, дүгнэлтийг тодорхойлон бичнэ.

9. Хүмүүсийн гаргасан эрэлт, хүсэлт, түүнд өгсөн хариу, газар дээр нь шийдвэрлээгүй бөгөөд Комиссоос анхаарвал зохих асуудлыг нэг бүрчилж жагсаан бичнэ.

10.Өөрийн санаачилгаар бусад зүйлийг мэдээлж болно.

И.Судалгааны явцад бүрдүүлсэн баримт, материал, статистик үзүүлэлт, гэрэл зураг, соронзон бичлэг зэргийг тайланд хавсаргана.

12.Судалгааны ажлын хөдөө томилолт, байр болон унааны зардлын тооцоог ня-ботой зохих журмын дагуу баримтаар хийж баримтыг тушаана.

Судалгааны тайланг боловсруулж бэлтгэнэ.

Эрх зүйн орчны талаар

Монгол улс дахь хүний итгэл үнэмшилтэй, үзэл бодолтой байх эрх нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт /Монгол улс 1974 онд нэгдэн орсон/-ын 18 дугаар зүйлд “Хүн бүр үзэл бодолтой байх эрх чөлөөтэй”, 19 дүгээр зүйлд “Хүн бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй”, “Хүн бүр тайван замаар сайн дураар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй. Хэнийг ч аливаа эвлэл холбоонд албадан оруулах ёсгүй”, түүнчлэн 25 дугаар зүйлийн “С”-д “иргэн бүр 2 дугаар зүйлд дурдсан аливаа ялгаваргүйгээр тэгш эрхийн нийтлэг нөхцөлтэйгөөр улсдаа төрийн алба хаах эрх ба боломжийг ямар нэг үндэслэлгүй хязгаарлалтгүй эдэлнэ” гэсэн олон улсын эрх зүйн тулгуур баримт бичгийн заалтуудаар баталгаажиг байна.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт Монгол улсын иргэн “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөтэй”, 10 дахь хэсэгт “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн байгууллага байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй”, 9 дэх хэсэгт “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжпан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй” гэсэн нь дээр дурдсан олон улсын эрх зүйн баримт бичгийн заалтуудад бүрнээ нийцэж байна.

Монгол улсын оролцсон олон улсын гэрээ болон Монгол улсын хуульд өөрөөр заагаагүй

бол иргэний итгэл үнэмшилтэй байх, үзэл санаагаа чөлөөтэй илэрхийлэх эрхийг ямар ч тохиолдолд төрөөс хязгаарлаж болохгүй. Энэ талаар Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад “Өөрийн үзэл бодолтой байх, сонгож авах гэсэн хэний ч эрх чөлөөг хязгаарлан хавчиж болохгүй” гэжээ.

Гэвч Монгол улсын зарим хуулийн заалт манай улсын хүлээн зөвшөөрсөн болон нэгдэн брсон олон улсын гэрээ хийгээд Монгол улсын Үндсэн хуулийн заалтад зарим талаар харшилж байгааг дараах байдлаас ажиглаж болно:

Тодруулга:

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2 дугаар зүйлийн 1-д “Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон эрх мэдэлдээ байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг улс төрийн болон бусад үзэл бодол ..., нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй”, мөн Пактын 25 дугаар зүйлийн “С”-д “Иргэн бүр ... тэгш эрхийн нийтлэг нөхцөлтэйгөөр улсдаа төрийн алба хаах эрх чөлөө ба боломжийг хязгаарлалтгүйгээр эдэлнэ” гэж заажээ.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт:

Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.

Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно гэжээ.

1. Төрийн албаны тухай хууль /1995/-ийн 13 дугаар зүйлийн 8-д “Төрийн захиргааны албан хаагч нь албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих нийтлэг үүрэг хүлээнэ” гэж заасан бөгөөд энэ нь “хүн бүр тайван замаар сайн дураар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэсэн Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 20 дугаар зүйлийн 1, “18 насанд хүрсэн иргэд сайн дураар эвлэлдэн нэгдэж, улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулах нам байгуулж болно. Төрийн албан хаагч албан тушаалын үүрэг гүйцэтгэхдээ аль нэг намын эрх ашгийн үүднээс бус гагцхүү улсын эрх ашгийн үүднээс хандаж эрх зүйн хэм хэмжээнд захирагдан ажиллана” гэсэн Улс төрийн намуудын тухай хуулийн 2 ба 4¹ дүгээр зүйлийн заалтыг зөрчиж байна. Өөрөөр хэлбэл, төрийн захиргааны албан хаагч намд эвлэлдэн нэгдсэнээр, намынхаа үзэл баримтлал, байр суурийг түгээн дэлгэрүүлснээр нийтийн аюулгүй байдал, хэв журмыг алдагдуулах зэргээр эрхийг нь хуулиар хязгаарлах ямар ч шаардлагагүй байхад ийнхүү хязгаарласан нь буруу юм. Харин төрийн тусгай албан хаагчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах шаардлага байдаг. Гэвч Монгол улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт цагдаагийн албан хаагч

улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулдаг эвсэл, холбооны гишүүн байхыг хориглосон байхад мөн зүйлийн 2 дахь хэсэгт цагдаагийн албан хаагч эвлэлдэн нэгдэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана гэсэн нь уг хуулийн заалтууд хоорондоо зөрчилтэй байгааг илтгэж байна.

2. Төрийн албаны тухай хуулийн төрийн захиргааны албан хаагч албан үүрэгтэйгээ холбоогүй асуудлаар намын байгууллагын үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн хувьд оролцохыг хориглох тухай зөвхөн төрийн захиргааны албан тушаалтныг онцолсон 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлаж байна. Нэгэнтээ олон улсын гэрээ болон Монгол улсын Үндсэн хууль, бусад хуулиар иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг улс төрийн үзэл бодол болон бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр хангах, аль нэгэн намд эвлэлдэн нэгдсэний төлөө хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхгүй байх, түүнчлэн төрийн жинхэнэ албан хаагч албан тушаалын үүрэг гүйцэтгэхдээ ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллах зарчим буй тул захиргааны албан хаагчийн намын үйл ажиллагаанд оролцох /үзэл бодолтой байх/ эрхийг хуулиар хязгаарлаж болохгүй. Харин ч ийнхүү хориглосон явдал тухайн сонгуулиар засгийн эрхэнд гарсан улс төрийн хүчин өөрийн намын хүмүүсээр багаа бүрдүүлэх, бусад намын гишүүн буюу тухайн намыг дэмждэг төрийн захиргааны ажилтныг халж, өөрчлөх чөлөөлөх, ажилд авахгүй байх зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэдэг байна.

Төрийн алба мэргэшсэн, тогтвортой байна гэж хууль /Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5/-иар тогтоосон зарчим ч хэрэгжихгүй болоход хүрч байна.

Төрийн албан хаагчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх

эрхийг хуулиар хязгаарлах талаар

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад хүн үзэл бодолтой байх буюу түүнийгээ илэрхийлэхэд зарим хязгаарлалттай байх боломжийг заажээ. Тухайлбал, дээрхи Пактын 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “Хүн бүр ... үзэл бодолтой байх эрх чөлөө зөвхөн хуулиар заасан бөгөөд нийтийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, мөн бусад хүний үндсэн эрх, эрх чөлөөг нэгэн адил хамгаалах ашиг сонирхлын үүднээс тогтоосон хязгаарлалттай байна”, Монгол улсын Үндсэн хууль /19 дүгээр зүйл/-д “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний ... итгэл үнэмшилтэй байхыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө” гэжээ. Энэ хязгаарлалтад хуульд заасны дагуу гол төлөв төрийн тусгай албан хаагчид, түүнчлэн намын гишүүнээс нь түдгэлзвэл зохих албан тушаалтнууд орж байна.

Тодруулга:

Цэргийн албан хаагч улс төрийн зорилгоор эвлэлдэн нэгдэх, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг эвсэл, холбооны гишүүн байхыг хориглоно.

Иргэний цэргийн үургийн болон цэргийн албан хаагчийн Эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн заалтаас Дипломат алба хаах хугацаандаа улс төрийн аливаа нам, хөдөлгөөний гишүүн байх, үйл ажиллагаанд нь аль нэг хэлбэрээр оролцохоос түдгэлзэх үүрэгтэй.

Дипломат албаны тухай хуулийн 11.1

Цагдаагийн алба хаагч улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулдаг эвсэл, холбооны гишүүн байх, цагдаагийн бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, эвсэл, холбооны улс төрийн үзэл баримтлалыг сурталчлахыг хориглоно.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1

Төрийн дор дурдсан албан тушаалд сонгууль болон томилолтоор ажиллаж байгаа улс төрийн аль нэгэн намын гишүүн, Монгол улсын иргэн уг албан тушаалд байх хугацаандаа намын гишүүнээсээ түдгэлзэнэ:

1/ Монгол Улсын Ерөнхийлөгч;

2/ бүх шатны шүүхийн дарга, орлогч дарга, гишүүн, шүүгч;

3/ бүх шатны прокурор, мөрдөн байцаагч;

4/ Монгол Улсын Зэвсэгт хүчин, Цагдаагийн болон Улсын аюулгүй байдлыг хангах, Засан хүмүүжүүлэх байгууллагын байнгын бие бүрэлдэхүүний бүх албан хаагч;

5/ Монгол Улсын гадаад харилцааны дипломат ажилтан;

6/ Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, ажилтан.

7/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, ажилтан 8/ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн.

Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуулийн 1 дүгээр зүйл

Харин уг хязгаарлалтыг төрийн захиргааны албан тушаалтанд заавал хамааруулах үндэсгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Төрийн албан хаагчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарласан хуулийн заалтууд янз бүрээр томъёологдсон, тухайлбал, Үндсэн хуулийн Цэцийн тухай хууль /1992/-ийн 3 дугаар зүйлийн 5, Шүүхийн тухай хууль /1993/-ИЙН 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,

Прокурорын байгууллагын тухай хууль /1993/-ИЙН 29 дүгээр зүйлийн 1, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль /2000/-ийн 21 дүгээр зүйлийн 1-д тус тус тухайн байгууллага, албанд нам, улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэсэн байхад ИЦҮЦАХЭЗБХ-ын 29 дүгээр зүйлд цэргийн албан хаагч улс төрийн үйл ажиллагаа явуулдаг эвсэл, холбооны гишүүн байхыг хориглоно, Дипломат албаны тухай хуулийн 11.1 дүгээр зүйлд улс төрийн нам хөдөлгөөний гишүүн байх, үйл ажиллагаанд нь аль нэг хэлбэрээр оролцохоос түдгэлзэх үүрэгтэй, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цагдаагийн бие бүрэлдэхүүний дотор нам, эвсэл, холбооны улс төрийн үзэл баримтлалыг сурталчлахыг хориглоно” гэсэн нь нэг талаас төрийн албан хаагч улс төрийн нам, эвсэл, холбоонд эвлэлдэн нэгдэж болох боловч улс төрийн үйл ажиллагаа явуулж болохгүй, эсвэл аль нь ч болохгүй, нөгөө талаас нам, эвсэл, холбоонд нэгдэж болохгүй, харин улс төрийн үйл ажиллагааг явуулж болох мэтээр хоёрдмол утгаар ойлгогдохоор байгааг өөрчилж жигдрүүлэх шаардлагатай нь судалгааны явцад ажиглагдав.

**Төрийн албан хаагч үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх,
сонгон авах эрх чөлөөгөө хэрэгжүүлэхтэй холбогдон ажил албандаа хэрхэн тогтвор
суурьшилтай байгаа талаар хийсэн
судалгааны тухай**

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийг 1995 оноос эхлэн хүчин төгөлдөр • дагаж мөрдсөнөөс хойш төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэж ирсэн билээ.

Энэ хуулийн дагуу төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг төрийн захиргаа, тусгай болон үйлчилгээний алба алинд ч нэгэн адил хамааруулсан юм. Харин улс төрийн албаны хувьд түүнд ажиллаж байгаа албан тушаалтан сонгуулийн болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажилладаг, энэ бүрэн эрхийн хугацаа дуусмагц эрхэлж буй албан тушаалаасаа чөлөөлөгдөх буюу өөрчлөгдөж болдог онцлогтой билээ. Төрийн бусад албан тушаалтны хувьд өөрөө хүсэлт гаргасан болон хуульд заасан үндэслэлийн дагуу захиргаа санаачилсан зэргээс бусад үед тэднийг эрхэлсэн ажил, албанаас нь халж, өөрчлөх явдал төр, нийгэмд сөрөг үр дагавартай, үүнээс болж хүний эрх ашиг хохирдог. Энэ үүднээс төрийн албан хаагчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх хэрхэн хангагдаж байгаа буюу тэд тогтвор суурьшилтай ажиллаж байгаа эсэхийг судлахдаа дээрхи гурван төрлийн албан тушаал болон тэдгээрт ажиллаж байгаа албан хаагчдын ерөнхий хөдөлгөөнийг харьцуулах, үүний дотроос төрийн захиргааны албан хаагчдын асуудлыг онцолж үзэх шаардлага тавигдсан юм.

Төрийн захиргааны албаны зөвлөлөөс гаргасан судалгаагаар 1995 оноос хойш 2001 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл төрийн захиргаа, төрийн тусгай болон үйлчилгээний албан

тушаалаас 16838 хүн халагдаж чөлөөлөгджээ.

1995 он	1996 он	1997 он	1998 он	1999 он	2000 он	2001 оны эхний 8 сар	Бүгд
555	2761	1069	1058	4062	6788	545	16838

Тайлбар:

1 1995-1997 онд төрийн албанаас чөлөөлөгдсөн хумуусийн бүрэлдэхүүнд яам, агентлаг, төр, захиргааны бусад албан байгууллага, түүнчлэн аймаг, | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ажлын албанд ажиллагсад орсон бол 1998-2001 оны 9 дүгээр сарын 1-нийг хүртэлх хугацаанд уг албанаас 1 чөлөөлөгдсөн хүмүүсийн бүрэлдэхүүнд дээрх байгууллагуудын албан I хаагчдаас гадна сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ажиллагсад | орсон тул эхний 3 жилд хөдөлгөөний тоо, хувийн жин доогуур байгаа ажээ.

Гээдээ УИХ-ын болон орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль явагдсан тухайн онууд /1996,2000/-д төрийн албан хаагчдын халагдаж чөлөөлөгдсөн хөдөлгөөн эрс өссөн байгаа нь анхаарал татаж байна.

Жишээ:

1996 онд халагдаж чөлөөлөгдсөн хүний тоо 2761 байгаа нь урд оныхоос 2206- аар илүү. 2000 онд тийм хүний тоо 6788 байгаа нь урд оныхоосоо 2726-аар илүү юм.

Төрийн албанаас чөлөөлөгдсөн үндэслэл, шалтгааныг авч үзвэл албан тушаалтан өөрөө хүсэлт гаргасан, ажиллаж байгаа байгууллагад нь бүтцийн өөрчлөлт хийсэн, мөн албан тушаалтны эрүүл мэндийн байдлаас, мэргэжлийн түвшин нь ажлын шаардлага хангаагүй, гэмт хэрэг, сахилгын шийтгэл хүлээсэн,урт хугацааны сургалтад хамрагдсан, тэтгэвэрт гарсан, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн гэх мэт олон янз байна.

Үүний дотроос бүтцийн өөрчлөлт, өөрийн хүсэлтээр болон албан үүргээ хангалтгүй биелүүлсэн гэх үндэслэлүүд нь мөн сонгууль явагдсан тухайн онуудад нэмэгдэж, зонхилох хувийг эзэлж байна. 2000 оны сонгуулиас хойш гэхэд өөрийн хүсэлт болон бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн хүмүүс нийт халагдаж чөлөөлөгдсөн хүмүүсийн 58%-ийг эзэлж байна. Төв, орон нутгийн төр, захиргааны байгууллагын удирдлагын шийдвэрт хэдийгээр ажилтныг ажлаас халах үндэслэл, шалтгааныг аль нэг намын харьяалалтай холбож үзээгүй байгаа боловч хүмүүсийн гаргасан гомдлын үндэс нь тухайн ажилтан тэр үедээ засгийн эрх барьж байгаа намаас өөр намын харьяалалтай байснаар нь бүтцийн өөрчлөлт нэрээр шахан гаргах эсвэл удирдлагатай үзэл бодол тохирохгүй гэдэг байдлаар хүлээн зөвшөөрүүлж

өөрсдөөр нь чөлөөлөгдөх хүсэлт гаргуулах явдал байсан гэгцгээдэг. Төрийн албаны тухай хуульд байгууллагын бүтцийн өөрчлөлтийн улмаас захиргааны санаачилгаар төрийн захиргааны албан хаагчийг төрийн албанаас халах буюу чөлөөлөх үндэслэл заагаагүй билээ.

Төрийн захиргааны албан хаагчийн эрх зөрчигдсөн маргааныг Төрийн захиргааны албаны зөвлөл хуульд заасан үндсэн чиг үүргийнхээ дагуу хянан шийдвэрлэж байна. Уг Зөвлөлөөс энэ талаар сүүлийн 6 жилд гаргасан судалгаанаас үзэхэд 1995 оны 7 дугаар сарын 24-нөөс хойш 2001 оны 6 дугаар сарыг хүртэл хугацаанд иргэд /тангараг өргөсөн төрийн жинхэнэ албан хаагч байсан буюу төрийн албаны шалгалт өгч тэнцсэн/-ээс Төрийн захиргааны албаны зөвлөлд хандаж ажлаас үндэслэлгүйгээр халсан буюу ажилд авахгүй байгаа талаар нийт 165 өргөдөл, гомдол ирүүлжээ. Уг Зөвлөлийн гишүүн газар дээр нь очиж шалгах буюу төрийн захиргааны албаны салбар зөвлөлүүдээрээ дамжуулж, хурлаар хэлэлцүүлж өргөдөл өгсөн хүмүүсийн 56.3% буюу 93 хүнийг ажилд нь буцаан томилуулах буюу ажлаар хангуулж, 9.7% буюу 16 хүний ажлаас үндэслэлгүй халагдсаныг шүүхээр тогтоолгон хуучин ажилд нь буцаан оруулсан байна. Мөн 17 хүний асуудлыг шалгаж шийдвэрлүүлэхээр Төрийн захиргааны албаны холбогдох салбар зөвлөлүүдэд шилжүүлжээ.

Зарим байгууллага дээр хийсэн судалгааны талаар

Төрийн албан хаагчид, тэдгээрийн дотор төрийн захиргааны албан хаагчид үзэл санаагаа чөлөөтэй илэрхийлэх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон ажил албандаа хэрхэн тогтвор суурьшилтай ажиллаж байгаа талаар зарим төв, орон нутгийн байгууллага тухайлбал, Төв аймаг, Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, мөн Санхүү, эдийн засгийн яам, Гаалийн ерөнхий газрын хэмжээнд 1996 оноос 2001 оны 10 дугаар сар хүртэлх хугацааг хамруулан Хүний нөөцийн асуудлаар гаргасан удирдлагын тушаал, шийдвэр, бусад баримт бичгийг үзэж танилцах, холбогдох хүмүүстэй уулзах, ажиллагсдын дунд санал санал асуулга явуулах хэлбэрээр судалгаа явуулав. Эдгээр байгууллагууд дээр гол төлөв 1996, 2000 онд УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгууль болж, төр засгийн эрх барих нам, улс төрийн хүчний байршил солигдсоны дараа төрийн захиргааны албан хаагчдын ажилдаа тогтвор суурьшилтай байгаа эсэх асуудал ямар байгааг анхаарч судалсан юм.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяалалд сумдын Засаг даргын орлогчид болон Тамгын газрын дарга оролцсоноор 1996 оны сонгуулийн дараа 120 хүн ажиллаж байснаа 14, 2000 оны сонгуулийн дараа 126 хүн ажилласнаас 15, Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын харьяалалд хорооны зохион байгуулагчид орсноор 1996 оны сонгуулийн дараа 82 хүн ажиллаж байснаас 16, 2000 оны сонгуулийн дараа 85 хүн ажиллаж байснаас 18 хүнийг тус тус намын харьяалал болон үзэл бодлоос нь шалтгаалж ажлаас нь чөлөөлсөн байна. Эдгээр хүмүүсийг сонгууль болсны дараа 6 сарын дотор чөлөөлсөн, ийнхүү чөлөөлсөн шалтгааныг байгууллагын бүтцийн өөрчлөлттэй холбож байгаа боловч хэрэг дээрээ өмнөх засаг, төрийн эрх

баригч нам, улс төрийн хүчний харьяалалтай буюу үзэл бодолтой хүмүүсийг ажпаас нь халж, оронд нь тухайн үед засгийн эрхэнд гарсан нам, хүчний гишүүн болон үзэл баримтлалтай хүмүүсийг ажилд авчээ. Түүнчлэн Төв аймгийн Засаг даргын захирамжаар 1997 онд ажлаас нь чөлөөлсөн 9 хүн 2000 онд болсон сонгуулийн дараа эргээд хуучин ажил, албанд томилогдон ажиллаж байгаа, Баянгол дүүргийн Засаг даргын захирамжаар мөн 1997 онд ажпаас халагдсан 7 ажилтан Төрийн захиргааны албаны зөвлөлд гомдол гаргаж улмаар шүүхийн шийдвэрээр ажилдаа буцаан томилогдсон байна.

Санхүү, эдийн засгийн яаманд 2000 оны сонгуулиас хойш 97 хүн төрийн захиргааны албан хаагчаар ажиллаж байгаагаас 14 хүнийг бүтцийн өөрчлөлт нэрээр албан тушаалаас нь чөлөөлж 1 хүнийг бага тушаалын ажилд шилжүүлжээ. Эдгээр хүмүүсийн намын харьяаллыг авч үзвэл 9 нь Ардчилсан намын гишүүн болон дэмжигчид юм байна. Мөн тэдний дотор газар, хэлтсийн дарга болон орлогч 5 хүн байв.

1996 онд батлагдсан Монгол улсын Гаалийн тухай хуулийн дагуу гаалийн албаны ажилтнууд нь төрийн тусгай албанд харьяалагдаж ажил, албан тушаал эрхэлж байна. Гаалийн хяналтын албаны ажил, албан тушаалын онцлогоос хамаарч тэднийг ажпаас нь өөрчлөх, сэлгэн байршуулах асуудал байнга гардаг байна.

Гэвч гаалийн байгууллагад аливаа намын харьяалал буюу үзэл бодлоос нь шалтгаалж ажилтныг албан тушаалаас нь чөлөөлөх асуудал цөөнгүй гарч байна. 1996 оны 9 дүгээр сараас 2000 оны 9 дүгээр сар хүртэл Гаалийн ерөнхий газрын удирдлага мөн газрын төв аппарат болон орон нутгийн салбар, нэгжид удирдах тушаалын ажил эрхэлж байгаа 90 хүнээс 14-ийг албан тушаалаас нь чөлөөлж, оронд нь Ардчилсан намын гишүүн болон дэмжигчийг, 2000 оны 9 дүгээр сараас хойш 15 хүнийг мөн ажлаас нь чөлөөлж, оронд нь МАХН-ын гишүүн болон дэмжигчийг авч ажиллуулжээ. Эдгээр хүмүүсийн ажлаас халсан шалтгааныг өөр газар ажиллах болсон, өөрөө хүсэлт гаргасан гэсэн нь үндэслэл муутай байна.

ДҮГНЭЛТ

Монгол улс дахь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг хүн бүр сайн дураараа эвлэлдэн нэгдэх, төрийг удирдах хэрэгт оролцох боломжийн хүрээнд бүхэлд нь авч үзвэл, манай иргэд энэ төрлийн эрхийг зохих хэмжээгээр хэвийн эдэлж байгаа дүр төрх байна. Харин иргэн итгэл үнэмшилтэй байх эрхийг аливаа ялгаваргүй буюу хязгаарлалтгүй эдэлж байх гэсэн шууд утгаар Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал болон олон улсын эрх зүйн бусад баримт бичигт заасанчлан үзвэл энэ эрх Монгол улсад тодорхой хэмжээгээр зөрчигдөж байгаа буюу хэрэгжилтийн байдал хэвийн биш гэж үзэж болно. Үүнд:

1. Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 8, 15 дугаар зүйлийн

1 дэх хэсгийн заалтууд Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал болон олон улсын холбогдох гэрээнд заасан зарчим, үзэл санаа, түүнчлэн Монгол улсын Үндсэн хуулийн заалт /16 дугаар зүйлийн 10,

19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/-д нийцэхгүй байна. Ийнхүү хүний итгэл үнэмшилтэй байх эрх буюу чөлөөт үзэл санааг төрөөс императив хэм хэмжээ тогтоох замаар хязгаарлаж байгаа явдал нь хүмүүс үзэл бодлоор хуваагдан талцах, ялгаварлах, намчирхах буюу улс төржих, шударга бусаар аливаа эрх мэдэл, давуу байдал олж авахыг эрмэлзэх гэх мэт сөрөг үр дагавар үүсгэх, улмаар хүний эрх, эрх чөлөөг зөрчихөд хүргэх хандлагатай байгааг өөрчлөх шаардлагатай байна.

Түүнчлэн Шүүхийн тухай хууль, Дипломат албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай зэрэг хуулиудад төрийн албан хаагч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарласан заалтууд нь өөр өөр байдлаар томъёологдсон байгааг өөрчилж жигдрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

2. 1990-ээд оноос хойшхи хугацаанд төрийн албан хаагчдыг улс төрийн намын харьяаллаас нь шалтгаалан ажпаас өөрчлөх, халах үзэгдэл нийтлэг шинжтэй болжээ. Энэ нь ялангуяа, УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгууль явагдаж аль нэг нам, эвсэл, шинээр засгийн эрх барьж эхэлсэн тухайн жилд буюу түүний дараах эхний жилд нь илүүтэй гардгийг бодит тоо, жишээ баримт харуулж байна. Тусгайлан сонгож судалгаа хийсэн 4 байгууллагаас төрийн захиргааны албан хаагчид үндсэн нэгжийг нь бүрдүүлдэг Төв аймгийн болон Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Санхүү, эдийн засгийн яамны хэмжээгээр Ардчилсан холбоо эвсэл сонгуульд ялж засгийн эрх барьсан 1996 оны сонгуулийн дараа 30 хүн намын харьяаллаар ажпаас өөрчлөгдсөний 28 нь уг сонгуулийн эхний жилүүдэд, мөн эдгээр байгууллагуудын хувьд МАХН сонгуульд дийлэнхи олонхи болж төр барьж эхэлсэн 2000 оны сонгуулийн дараа 42 хүн намын харьяаллаар өөрчлөгдсөний 28 нь сонгууль явагдсан тухайн жилд ажпаас чөлөөлөгджээ. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Байгууллагын нэр	1996 оны сонгуулиар Ардчилсан холбоо эвсэл			2000 оны сонгуулиар МАХН		
	Бүгд	Эхний жилүүдэд	Хувь	Бүгд	Тухайн жилд	Хувь
Төв аймгийн ЗДТГ	14	14	100%	15	3	20%
Нийслэлийн БГД-ийн ЗДТГ	16	14	87.5%	18	16	88.8%
Санхүү, эдийн засгийн яам	=	=	=	9	9	100%

Бүгд	30	28	94.2%	42	28	66.6%
------	----	----	-------	----	----	-------

Төрийн албан хаагчийг намын харьяалал, үзэл бодлоос нь шалтгаалж ажлаас нь халж, өөрчлөх явдал аль ч нам, эвсэл засгийн эрх барьж буй үед нийтлэг байгаа нь дээрхи байдлаас харагдана. Энэ оны 4-7 дугаар сард хүний эрхийн төлөв байдлын судалгаа явуулсны дараа ирүүлсэн 12 аймгийн тайланд ч энэ талаар дүгнэлт, жишээ баримт дурдсан ажээ. Бидний явуулсан анкетын санал асуулгын дүн үүнийг бас давхар гэрчилж байгаа болно.

3. УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгууль явагдаж төр, засгийн эрх барих нам улс төрийн хүчний байр солигдсон үед төр, захиргааны аль ч байгууллагад бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийдэг “муу зуршил” тогтсон байгаа нь төрийн албан хаагчийг ажил албанаас нь халж өөрчлөх нэг арга болж байна. Бидний тусгайлж судалгаа явуулсан 4 байгууллагад бүгдэд нь “бүтцийн өөрчлөлт” хийжээ.

Шинжлэх ухаан, технологи хөгжиж салбар бүрт компьютер, цахим техник нэвтэрч байгаа өнөө үед ажлын байр, орон тоо, төсөв, цалингийн сан багасах, ялангуяа, үйлдвэр, аж ахуйн газарт ийм шалтгаанаар ажиллагсдыг бөөнөөр нь халах асуудал гарахыг үгүйсгэхгүй.

Хөдөлмөрийн хууль /1999 он/-д хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачилгаар цуцалж болох нэг үндэслэл бол аж ахуйн нэгж, байгууллага болон түүний салбар нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, эсхүл ажилтны тоог цөөрүүлсэн байх явдал гэж үзжээ. Гэтэл төрийн байгууллагыг сонгох сонгууль болсны дараа төсөв, ажлын байр, орон тоо, цалингийн сан өөрчлөгдөөгүй хэвээр байгаа нөхцөлд байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг өөрчилнө гэдэг нь түүнийг боловсронгуй болгох буюу хямдруулах үүднээс биш ажилтныг үзэл бодлоор нь ялгаварлаж халж солих зорилготой байжээ гэж үзэх үндэслэлтэй байна. Үүнээс үзэхэд, Хөдөлмөрийн хуулийн заалт /40.1.1/ үндэслэж байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн гэдэг шалтгаанаар төрийн албан хаагчдыг ажлаас нь халж, өөрчилж байгаа практикийг буруутай үзэж байна.

Иргэний үзэл бодолтой байх эрхийн хэрэгжилтийн талаар явуулсан энэхүү судалгаатай холбогдуулж Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь төрийн дээд өндөрлөгүүдийг зохих мэдээллээр хангах, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах, төрийн захиргааны албаны зөвлөл болон хууль, хяналтын байгууллагатай хамтарч шаардлагатай зарим газар шалгалт хийх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авах тухай саналыг УИХ болон Засгийн газарт оруулж байна.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

/Судалгааны тайлан/

Хүн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх явдал нь уг хүний төрөлхийн бөгөөд салшгүй эрх юм. Энэхүү эрхээ эдлэхдээ хүн үзэл санаагаа амаар, бичгээр эсвэл хэвлэлээр, уран сайхны хэлбэрээр түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй илэрхийлж болно. Ийнхүү өөрийн сонгох аргад нам, эвлэл, ҮЭ-ийн байгууллага болон бусад олон нийтийн байгууллагыг үүсгэн байгуулах, түүнд эвлэлдэн нэгдэх, үзэл санаагаа ганцаар болон бусадтай хамтарч илэрхийлэх явдал хамаарна.

Эрх чөлөөтэй, амар амгалан амьдрах итгэл үнэмшил хүнд байхгүй бол тэр хүн үзэл бодолтой байж түүнийгээ илэрхийлэх эрхээ хамгаалуулна гэх нь утгагүй юм. Харин үзэл бодолтой хүнийг амьдрах итгэлтэй хүн гэж хэлнэ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд “Итгэл үнэмшилтэй байх нь хүн ардын эрхэм дээд эрмэлзэл мөн” хэмээн заасан нь хүн ухамсартай, түүгээрч үл барам итгэл үнэмшилтэй байдаг, тэр нь амьдралын нь залуур болдгоороо бусад амьтдаас ялгаатай гэдгийг онцолсон хэрэг. Ингэхдээ хүн зөвхөн ухамсартайгаар амьдрах төдийгүй орон байр, хоол хүнс, хувцас өлгөө оролцуулан нийгмийн баялгийг бүтээдэг, үр хүүхдээ өсгөж, хөгшид настнаа асардаг, улс нийгмийн амьдралд оролцож, төрийг удирдахад ч хүчин зүтгэдэг.

Монгол улсад иргэд төрийг удирдах хэрэгт оролцох эрх нь тэдний төрийн байгууллагад сонгох, сонгогдох, өөрсдийн болон нийгмийн ашиг сонирхлын үүднээс нам, олон нийтийн байгууллага байгуулах, тэдгээрт сайн дураар эвлэлдэн нэгдэх, улсдаа төрийн алба хаах явдлаар дамжин хэрэгждэг билээ. Үүний сүүлчийнхэд хамааралтай төрийн албан хаагч үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх манай улсад хэрхэн хэрэгжиж байгаа асуудал нь мөн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, нам, олон нийтийн байгууллагад сайн дураар эвлэлдэн нэгдэх зэрэг бусад улс төрийн болон хувийн эрхийн хэрэгжилттэй салшгүй холбоотой байдаг тул ХЭҮК үүнийг анхааралдаа авч тусгайлан судалгаа хийж байгаа юм. Хүний итгэл үнэмшилтэй байх болон үзэл бодолтой байх эрх хоорондоо салшгүй холбоотойн талаар дээр тэмдэглэсэн. Харин төрийн албан хаагчийн хувьд үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх гэдгээр томьёолж судалгааны асуудалд хандах нь илүү нийцтэй байгаа юм.

Монгол улс дахь хүний итгэл үнэмшилтэй, үзэл бодолтой байх эрх нь НҮБ-аас баталсан Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын “Оршил” хэсэгт “хүмүүс итгэл үнэмшилтэй байх ... нь хүн ардын эрхэм дээд эрмэлзэл мөн”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт /Монгол улс 1974 онд нэгдэн орсон/-ын 2 дугаар зүйлийн 1-д “энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон эрх мэдэлдээ байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг улс төрийн үзэл бодол болон бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй” гээд мөн Пактын 20 дугаар зүйлд “хүн бүр тайван замаар сайн дураар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй. Хэнийг ч аливаа эвлэл холбоонд албадан оруулах ёсгүй”, түүнчлэн 25

дугаар зүйлийн “С”-д “иргэн бүр 2 дугаар зүйлд дурдсан аливаа ялгаваргүйгээр тэгш эрхийн нийтлэг нөхцөлтэйгөөр улсдаа төрийн алба хаах эрх ба боломжийг ямар нэг үндэслэлгүй хязгаарлалтгүй эдэлнэ” гэсэн олон улсын эрх зүйн тулгуур баримт бичгийн заалтуудаар баталгаажиг байна.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт Монгол улсын иргэн “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөтэй”, 10 дахь хэсэгт “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн байгууллага байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй”, 9 дэх хэсэгт “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжпан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй” гэсэн нь дээр дурьдсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн заалтуудад бүрнээ нийцэж байгаа билээ.

Тодруулга:

Түүнчлэн Олон улсын эрх зүйн баримт бичиг, тухайлбал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 25 дугаар зүйлд зааснаар иргэн төрийн хэргийг явуулахад оролцох эрхийн нэг хэлбэр нь төрийн алба хаах болон сонгох, сонгогдох зэргээр үйл ажиллагаа явуулах эрх ба боломж гэж үзжээ.

Иргэн өөрийн итгэл үнэмшилтэй, үзэл бодолтой байх нь түүний төрөлхийн бөгөөд заяамал эрх, харин сайн дураараа эвлэлдэн нэгдэх буюу төрийг удирдах хэрэгт оролцох нь үүсмэл бөгөөд олдмол эрх юм. Үүнээс ургуулан үзэхэд иргэдийн сайн дураар эвлэлдэн нэгдэж байгуулсан намыг төрийн байгууллага бүртгэх буюу бүртгэхээс тодорхой үндэслэлээр татгалзах, эсвэл иргэнийг ажил, албан тушаалаас нь хуульд заасан үндэслэлээр халж, чөлөөлж, өөрчилж болох боловч иргэний өөрийн итгэлээр сонгосон намынхаа үзэл баримтлалтай байх, түүнийг дэмжих, өөрчлөх, түүнээс татгалзах эрх чөлөөг хэн ч, ямар ч байгууллага, албан тушаалтан өөрчлөх буюу хязгаарлах боломжгүй юм. Нэг үгээр хэлэхэд, иргэний итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ямар ч тохиолдолд төрөөс хязгаарлаж болохгүй.

Тодруулга:

“Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний итгэл үнэмшилтэй байх[^]. Хуулийн заалтыг үл хөндөнө”. Монгол улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалт

Гэвч Монгол улсын зарим хуулийн заалт манай улсын хүлээн зөвшөөрсөн болон нэгдэн орсон олон улсын гэрээ хийгээд Монгол улсын Үндсэн хуулийн заалтад харшилж байгааг дараах байдлаас ажиглаж болно:

Тодруулга: Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2 дугаар зүйлийн 1-д “Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон эрх мэдэлдээ байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг улс төрийн болон бусад үзэл бодол .., нөхцөл байдлаар

ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах уурэгтэй”, мөн Пактын 25 дугаар зүйлийн “С”-д “Иргэн бүр ... тэгш эрхийн нийтлэг нөхцөлтэйгөөр улсдаа төрийн алба хаах эрх чөлөө ба боломжийг хязгаарлалтгүйгээр эдэлнэ” гэж заажээ.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт:

Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.

Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно гэжээ.

1. Төрийн албаны тухай хууль /1995/-ийн төрийн захиргааны албан хаагч албан үүрэгтэйгээ холбоогүй асуудлаар намын байгууллагын үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн хувьд оролцохыг хориглох тухай зөвхөн төрийн захиргааны албан тушаалтныг онцолсон 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлаж байна. Нэгэнтээ олон улсын гэрээ болон Монгол улсын Үндсэн хууль, бусад хуулиар иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг улс төрийн үзэл бодол болон бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр хангах, аль нэгэн намд эвлэлдэн нэгдсэний төлөө хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхгүй байх, түүнчлэн төрийн жинхэнэ албан хаагч албан тушаалын үүрэг гүйцэтгэхдээ ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллах зарчим буй тул захиргааны албан хаагчийн намын үйл ажиллагаанд оролцох /үзэл бодолтой байх/ эрхийг хуулиар хязгаарлаж болохгүй. Харин ч ийнхүү хориглосон явдал тухайн сонгуулиар засгийн эрхэнд гарсан улс төрийн хүчин өөрийн намын хүмүүсээр багаа бүрдүүлэх, бусад намын гишүүн буюу тухайн намыг дэмждэг төрийн захиргааны ажилтныг халж, өөрчлөх чөлөөлөх, ажилд авахгүй байх зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэдэг.

Төрийн алба мэргэшсэн, тогтвортой байна гэж хууль /Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5/-иар тогтоосон зарчим ч хэрэгжихгүй болоход хүрч байна. Энэ талаархи жишээ баримтыг хойно үзнэ үү.

2. Төрийн албаны тухай хууль /1995/-ийн 13 дугаар зүйлийн 8-д “Төрийн захиргааны албан хаагч нь албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих нийтлэг үүрэг хүлээнэ ” гэж заасан бөгөөд энэ нь “хүн бүр тайван замаар сайн дураар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэсэн Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 20 дугаар зүйлийн 1, Монгол улсын иргэн нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс намын байгууллага байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй. Аль нэгэн намд эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглох тухай Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10, Улс

төрийн намуудын тухай хуулийн 2 ба 4¹ дүгээр зүйлийн заалтыг зөрчиж байна.

Тодруулга:

18 насанд хүрсэн БНМАУ-ын иргэд сайн дураар эвлэлдэн нэгдэж, улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулах нам байгуулж болно.

Төрийн албан хаагч албан тушаалын үүрэг гүйцэтгэхдээ аль нэг намын эрх ашгийн үүднээс бус гагцхүү улсын эрх ашгийн үүднээс хандаж эрх зүйн хэм хэмжээнд захирагдан ажиллана.

Улс төрийн намуудын тухай хуулийн 2 ба 4¹ заалтаас

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт цагдаагийн албан хаагч улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулдаг эсвэл, холбооны гишүүн байхыг хориглосон байхад мөн зүйлийн 2 дахь хэсэгт цагдаагийн албан хаагч эвлэлдэн нэгдэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана гэсэн нь уг хуулийн заалтууд хоорондоо зөрчилтэй байгааг илтгэж байна. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад хүн үзэл бодолтой байх буюу түүнийгээ илэрхийлэхэд зарим хязгаарлалттай байх боломжийг заасан байна. Тухайлбал, дээрхи Пактын 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “Хүн бүр ... үзэл бодолтой байх эрх чөлөө зөвхөн хуулиар заасан бөгөөд нийтийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, мөн бусад хүний үндсэн эрх, эрх чөлөөг нэгэн адил хамгаалах ашиг сонирхлын үүднээс тогтоосон хязгаарлалттай байна” гэжээ. Энэ хязгаарлалтад хуульд заасны дагуу гол төлөв төрийн тусгай албан хаагчид, түүнчлэн намын гишүүнээс нь түдгэлзвэл зохих албан тушаалтнууд орж байна.

Тодруулга:

Цэргийн албан хаагч улс төрийн зорилгоор эвлэлдэн нэгдэх, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг эвсэл, холбооны гишүүн байхыг хориглоно.

Иргэний цэргийн уургийн болон цэргийн албан хаагчийн Эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн заалтаас

Дипломат алба хаах хугацаандаа улс төрийн аливаа нам, хөдөлгөөний гишүүн байх, үйл ажиллагаанд нь аль нэг хэлбэрээр оролцохоос түдгэлзэх үүрэгтэй.

Дипломат албаны тухай хуулийн 11.1

Цагдаагийн алба хаагч улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулдаг эвсэл, холбооны гишүүн байх, цагдаагийн бие бүрэлдэхууний дотор аль нэг нам, эвсэл, холбооны улс төрийн үзэл баримтлалыг сурталчлахыг хориглоно.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1

Төрийн дор дурдсан албан тушаалд сонгууль болон томилолтоор ажиллаж байгаа улс төрийн аль нэгэн намын гишүүн, Монгол улсын иргэн уг албан тушаалд байх хугацаандаа намын гишүүнээсээ түдгэлзэнэ:

1/ Монгол Улсын Ерөнхийлөгч ;

2/ бух шатны шүүхийн дарга, орлогч дарга, гишүүн, шүүгч;

3/ *бух шатны прокурор, мөрдөн байцаагч;*

4/ *Монгол Улсын Зэвсэгт хүчин, Цагдаагийн болон Улсын аюулгүй байдлыг хангах, Засан хумуужуулэх байгууллагын байнгын бие бүрэлдэхүүний бүх албан хаагч;*

5/ *Монгол Улсын гадаад харилцааны дипломат ажилтан;*

6/ *Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн өрөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, ажилтан.*

7/ *Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, ажилтан*

8/ *Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн.*

***Намын гишүүнээс түдгэлзвэл зохих
албан тушаалын тухай хуулийн 1 дүгээр зүйл***

Харин уг хязгаарлалтыг төрийн захиргааны албан тушаалтанд заавал хамааруулах үндэсгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

3. Үндсэн хуулийн Цэцийн тухай хууль /1992/-ийн 3 дугаар зүйлийн 5-д Цэцийн гишүүн нам-улс төрийн үйл ажиллагаа эрхэлж болохгүй”, Шүүхийн тухай хууль /1993/-ИЙН 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх, шүүхийн байгууллагад улс төрийн нам, эвсэл, холбоо, хөдөлгөөний үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Прокурорын байгууллагын тухай хууль /1993/-ийн 29 дүгээр зүйлийн 1-д “Прокурорын байгууллагад улс төрийн нам, холбоо, эвсэл, хөдөлгөөний үйл ажиллагаа явуулахыг хориглоно, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль /2000/-ийн 21 дүгээр зүйлийн 1-д “Комисс, түүний ажлын албанд улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтууд хүн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх боломжийг хязгаарлаж байна. Төрийн албан хаагч /түүний дотор төрийн захиргааны болон тусгай/ улс төрийн үйл ажиллагаа явуулж болохгүй гэсэн нэг нийтлэг зарчмыг гол болгожээ. Улс төрийн үйл ажиллагаа гэж юу вэ? Энд холбогдох төрийн албан хаагч аль нэг намын гишүүн мөн, бишийн тухай асуудал тавигдаагүй шиг байна /Н.Д/. Явцуу утгаар нь авч үзвэл, улс төрийн үйл ажиллагаа гэдэг нь, гагцхүү аль нэг нам, хүчнийг сонгуульд ялуулахын төлөө тэмцэл, ялсан намын Засгийн газар тодорхой хугацаанд төрийн эрх барих явдал бөгөөд сонгуульд иргэн бүр тэгш эрхтэй оролцдог шүү дээ. Үүнээс өөр улс төрийн үйл ажиллагаа гэж байхгүй. Тэгэхээр төрийн албан хаагч улс төрийн үйл ажиллагаа явуулж болохгүй гэдэг нь иргэн сонгуульд оролцож болохгүй гэдэгтэй утга ойр юм. Хэрэв өргөн утгаар нь авч үзвэл, улс төргүй буюу сонгуульд ялсан намын төр засгийн байгууллагын оролцоогүй эсхүл тухайн намын үзэл баримтлал, оролцоогүй шийдвэрлэдэг нэг ч асуудал байдаггүй, үүнд төрийн албан хаагч аль ч иргэний нэгэн адил оролцох боломжтой. Харин улс төрийн намуудын тухай хууль /1991/-ийн 4¹ дүгээр зүйлд заасанчлан “Төрийн албан хаагч албан тушаалын үүрэг гүйцэтгэхдээ аль нэг намын эрх ашгийн үүднээс бус гагцхүү улсын эрх ашгийн үүднээс хандаж эрхзүйн хэм хэмжээнд захирагдан ажиллана” гэсэн нь иргэний үзэл бодолтой байх эрхийг хөндөхгүй /хязгаарлахгүй/ байна.

Монгол улсад хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх хэрхэн хангагдаж буй, өнөөгийн

төлөв байдал, ялангуяа, төрийн захиргааны албан хаагчдын хувьд үзэл бодолтой байх эрхийн хэрэгжилт ямар байгаа талаар баримт, мэдээлэл цуглуулан авч анализ хийж үзлээ. Мөн Төв аймаг, Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Санхүү, эдийн засгийн яам, Гаалийн ерөнхий газарт төрийн захиргааны болон тусгай, үйлчилгээний албан хаагчдыг эрхэлж байсан ажил, албан тушаалаас нь халж чөлөөлсөн байдлыг судлав. Энэхүү судалгаанд 1996 оноос 2001 оны 9 дүгээр сарын 1-нийг хүртэлх тоо баримт, статистикийн мэдээ сэлт түүвэрлэгдсэн болно.

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг төрийн захиргаа, тусгай болон үйлчилгээний алба алинд ч нэгэн адил хамааруулсан юм. Харин улс төрийн албан тушаалтны хувьд сонгуулийн болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажилладаг /мөн тэдгээрийн бүрэн эрхийнх нь хугацаанд өөрт нь уйлчлэх орон тооны ажилтан мөн тийм журмаар ажилладаг/, энэ бүрэн эрхийн хугацаа дуусмагц эрхэлж буй албан тушаалаасаа чөлөөлөгдөх буюу өөрчлөгдөж болдог онцлогтой билээ. Харин төрийн бусад албан тушаалтны хувьд өөрөө күсэлт гаргасан, хуульд заасан үндэслэлийн дагуу захиргаа санаачилсан зэргээс бусад үед тэднийг эрхэлсэн ажил, албанаас нь халж, өөрчлөх явдал гөр, нийгэмд сөрөг үр дагавартай, үүнээс болж хүний эрх ашиг хохирох нь эйлгомжтой. Энэ үүднээс төрийн албан хаагчийн үзэл бодлоо чөлөөтэй ллэрхийлэх эрх хэрхэн хангагдаж байгаа буюу тэд тогтвор суурьшилтай ажиллаж байгаа эсэхийг судлахдаа дээрхи гурван төрлийн албан тушаал болон гэдгээрт ажиллаж байгаа албан хаагчдын ерөнхий хөдөлгөөнийг харьцуулах, үүний дотроос төрийн захиргааны албан хаагчид тухайн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгааг онцолж үзэх шаардлага тавигдсан юм.

Төрийн захиргааны албаны зөвлөлөөс гаргасан судалгаагаар Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн 1995 оноос хойш 2001 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл төрийн захиргаа, төрийн тусгай болон үйлчилгээний албан тушаалаас 16838 хүн халагдаж чөлөөлөгджээ¹.

Жишээ нь

1995 он	1996 он	1997 он	1998 он	1999 он	2000 он	2001 оны эхний сар	Бүгд
555	2761	1069	1058	4062	6788	545	16838

1995-1997 онд төрийн албанаас чөлөөлөгдсөн хүмүүсийн бүрэлдэхүүнд яам, агентлаг, төр, захиргааны бусад албан байгууллага, түүнчлэн аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын

ажлын албанд ажиллагсад орсон бол 1998-2001 оны 11 дүгээр сарын 5-ныг хүртэлх хугацаанд уг албанаас чөлөөлөгдсөн хүмүүсийн бүрэлдэхүүнд дээрх байгууллагуудын албан хаагчдаас гадна сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ажиллагсад орсон тул эхний 3 жилд хөдөлгөөний тоо, хувийн жин доогуур байгаа ажээ.

Гэхдээ УИХ-ын болон орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль явагдсан тухайн онууд /1996,2000/-д төрийн албан хаагчдын халагдаж чөлөөлөгдсөн хөдөлгөөн эрс өссөн байгаа нь анхаарал татаж байна.

Жишээ:

1996 онд халагдаж чөлөөлөгдсөн хүний тоо 2761 байгаа нь урд оныхоос 2206- аар илүү. 2000 онд тийм хүний тоо 6788 байгаа нь урд оныхоосоо 2726-аар илүү юм.

Төрийн албанаас чөлөөлөгдсөн үндэслэл, шалтгааныг авч үзвэл албан тушаалтан өөрөө хүсэлт гаргасан, ажиллаж байгаа байгууллагад нь бүтцийн өөрчлөлт хийсэн, мөн албан тушаалтны эрүүл мэндийн байдлаас, мэргэжлийн түвшин нь ажлын шаардлага хангаагүй, гэмт хэрэг, сахилгын шийтгэл хүлээсэн, уртхугацааны сургалтад хамрагдсан, тэтгэвэрт гарсан, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн гэх мэт олон янз байна.

Үүний дотроос бүтцийн өөрчлөлт, өөрийн хүсэлтээр болон албан үүргээ хангалтгүй биелүүлсэн гэх үндэслэлүүд нь мөн сонгууль явагдсан тухайн онуудад нэмэгдэж, зонхилох хувийг эзэлж байна. 2000 оны сонгуулиас хойш гэхэд өөрийн хүсэлт болон бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн хүмүүс нийт халагдаж чөлөөлөгдсөн хүмүүсийн 58%-ийг эзэлж байна. Төв, орон нутгийн төр, захиргааны байгууллагын удирдлагын шийдвэрт хэдийгээр ажилтныг ажлаас халах үндэслэл, шалтгааныг аль нэг намын харьяалалтай холбож үзээгүй байгаа боловч хүмүүсийн гаргасан гомдлын үндэс нь тухайн ажилтан тэр үедээ засгийн эрх барьж байгаа намаас өөр намын харьяалалтай байснаар нь бүтцийн өөрчлөлт нэрээр шахан гаргах эсвэл удирдлагатай үзэл бодол тохирохгүй гэдэг байдлаар хүлээн зөвшөөрүүлж өөрсдөөр нь чөлөөлөгдөх хусэлт гаргуулах явдал байсан гэцгээдэг. Төрийн албаны тухай хуульд байгууллагын бүтцийн өөрчлөлтийн улмаас захиргааны санаачилгаар төрийн захиргааны албан хаагчийг төрийн албанаас халах буюу чөлөөлөх үндэслэл заагаагүй билээ.

1996-1999 төрийн захиргааны албан хаагчдыг ажпаас халж, өөрчилсөн талаар МАХН-ын төв байгууллагын гаргасан танилцуулгад² “1996-1999 онуудад төрийн албанаас нийтдээ 54 000 орчим хүн халагдаж, чөлөөлөгджээ. Мөн 1996 оны сүүлийн хагаст 3536, 1997 онд 5274, 1998 онд 1104, 1999 онд 427, бүгд 10374 хүнийг намын харьяаллаар буюу МАХН-ын гишүүдийг төрийн захиргааны албан тушаалаас халж өөрчилсөн бөгөөд тэднийг бүтцийн өөрчлөлт, өөрийн хүсэлт, мэргэжлийн түвшин шаардлага хангаагүй гэсэн категорт оруулсан байна” гэжээ.

2000 онд УИХ-ын сонгууль явагдаж МАХН-ын дийлэнх олонхи болж засгийн эрхэнд гарснаас хойш 15 000 орчим төрийн албан хаагчийг үзэл бодлоор нь ялгаварлаж ажлаас нь халсан тухай

Ардчилсан намын баримт бичигт дурдсан байна.³


Төрийн захиргааны албан хаагчийн эрх зөрчигдсөн маргааныг Төрийн захиргааны албаны зөвлөл хуульд заасан үндсэн чиг үүргийнхээ дагуу хянан шийдвэрлэж байна. Уг Зөвлөлөөс энэ талаар сүүлийн 6 жилд гаргасан судалгаанаас үзэхэд 1995 оны 7 дугаар сарын 24-нөөс хойш 2001 оны 6 дугаар сарыг хүртэл хугацаанд иргэд /тангараг өргөсөн төрийн жинхэнэ албан хаагч байсан буюу төрийн албаны шалгалт өгч тэнцсэн/-ээс Төрийн захиргааны албаны зөвлөлд хандаж ажлаас үндэслэлгүйгээр халсан буюу ажилд авахгүй байгаа талаар нийт 165 өргөдөл, гомдол ирүүлжээ. Уг Зөвлөлийн гишүүн газар дээр нь очиж шалгах буюу төрийн захиргааны албаны салбар зөвлөлүүдээрээ дамжуулж, хурлаар хэлэлцүүлж өргөдөл өгсөн хүмүүсийн 56.3% буюу 93 хүнийг ажилд нь буцаан томилуулах буюу ажлаар хангуулж, 9.7% буюу 16 хүний ажлаас үндэслэлгүй халагдсаныг шүүхээр тогтоолгон хуучин ажилд нь буцаан оруулсан байна. Мөн 17 хүний асуудлыг шалгаж шийдвэрлүүлэхээр Төрийн захиргааны албаны холбогдох салбар зөвлөлүүдэд шилжүүлжээ.⁴

Дээрхи өргөдөл өгсөн нийт хүмүүсийн 66%-ийг ажилд нь буцаан томилсон буюу өөр ажлаар хангасан байгаагаас үзвэл төрийн захиргааны албан хаагчийг ажлаас нь үндэслэлгүйгээр халах буюу чөлөөлж байжээ.

Тусгайлан судалгаа хийсэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд дээр байдал ямар байгаа талаар дараах жишээ баримтуудаас ажиглаж болно.

1. Төв аймгийн Засаг даргын Тамгын газар

Аймгийн Засаг дарга ажилд томилох буюу ажлаас нь чөлөөлж, өөрчилж болох төрийн захиргааны албан тушаалтан **1996** онд болсон сонгуулийн дараах бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр 120 хүн, 2000 онд болсон сонгуулийн дараа **126** хүн байв. Энэ бүрэлдэхүүнд сумын Засаг даргын орлогчид болон Тамгын газрын дарга нар хамрагдаж байгаа юм. **1996** оны сонгуулийн дараа томилогдон ажилласан аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд төрийн захиргааны албан хаагч **42** хүн ажлаас халагдаж өөрчлөгдсөн бөгөөд тэдний дотроос **/33.3** хувь буюу/ **14** хүнийг үзэл бодолтой нь холбон ажлаас нь халсан гэх үндэстэй байна. Эдгээр хүмүүс зөвхөн **1997** оны эхний 3 сард халагдсан билээ. **2000** оны сонгуулийн дараа томилогдон ажилласан Засаг даргын үед **26** хүн ажлаас өөрчлөгдсөний дотор **/57.6** хувь буюу/ **15** хүнийг мөн үзэл бодлоос нь шалтгаалж эрхэлж буй албан тушаалаас нь халж өөрчилсөн болох нь судалгаагаар илэрч байна.



эерсдийн хүсэлтээр гэж үндэслэжээ. Гэвч бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт 'эдэг нь газар, хэлтэс, харьяалах салбар, нэгжийн нэрийг өөрчлөх төдийгөөр ажлын байрыг нь хэвээр үлдээж түүнд тухайн үед засгийн эрх барьж буй хүчин өөрийн намын гишүүн буюу дэмжигчийг томилон ажиллуулж байгаа нь илт байв.

Түүнчлэн Төв аймгийн Засаг даргын захирамжаар 1997-1998 онд ажлаас нь чөлөөлсөн 9 хүн 2000 онд болсон сонгуулийн дараа эргээд хуучин ажил, албандаа томилогдон ажиллаж байгаа нь төрийн албан хаагчийг намын харьяалал болон үзэл бодлоос нь шалтгаалж албан тушаалаас халж чөлөөлж байгааг хөдөлшгүй гэрчилнэ.

2. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар

Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын харьяалалд 1996 оны сонгуулийн дараа 82, 2000 оны сонгуулийн дараа 85 хүн /төрийн захиргааны албан хаагч/ ажиллаж байна. Энэ бүрэлдэхүүнд хорооны зохион байгуулагчид хамрагдаж байгаа юм. Дүүргийн Засаг дарга 1996 оны орон нутгийн сонгуулийн дараа томилогдон ажиллахдаа 16 хүн /нийт захиргааны албан хаагчдын 19.5%/-ийг, 2000 оны сонгуулиас хойш 18 хүн /захиргааны албан хаагчдын 21.1%/-ийг тус тус халж чөлөөлжээ. Дээрхи хүмүүсийг ажил, албан тушаалаас нь халж, чөлөөлсөн үндэслэл нь бүтцийн өөрчлөлт гэж байгаа боловч хэрэг дээрээ намын харьяаллаас шалтгаалсан байна. 1997 онд ажлаас халагдсан 7 ажилтан Төрийн захиргааны албаны зөвлөлд гомдол гаргаж, улмаар шүүхийн шийдвэрээр ажилдаа буцаан томилогджээ.

Баянгол дүүргийн Засаг дарга 1997-1999 онд төрийн үйлчилгээний албан тушаалд хамаарах ерөнхий боловсролын дунд сургуулийн захирал 17 хүнийг, цэцэрлэгүүдийн эрхлэгч 18 хүнийг тус тус ажлаас нь халж чөлөөлжээ.

Жишээ:

Ажил. албанаасаа чөлөөлөгдсөн захирлуудын 7 буюу 41.1% нь намын харьяаллаас болсон гэж үздэг ба 3 хүн шүүхэд гомдлоо гаргаж албан ажилдаа эргэж орсон байна.

3. Санхүү, эдийн засгийн яам

Сайдын мэдлийн албан тушаалд ажилладаг төрийн захиргааны албан хаагч 1996 онд 94, 2000 онд 97 хүн байна. 1996-2000 он хүртэл үзэл бодлоор нь буюу аливаа намын харьяаллаас шалтгаалж төрийн захиргааны албан хаагчийг албан тушаалаас нь халж, чөлөөлөөгүй байна. Харин 2000 оны УИХ-ын сонгуулиас хойш Санхүү, эдийн засгийн сайдын захирамжаар 14 хүнийг бүтцийн өөрчлөлт нэрээр албан тушаалаас нь чөлөөлж, 1 хүнийг бага тушаалын ажилд шилжүүлжээ. Эдгээр хүмүүсийн намын харьяаллыг авч үзвэл, 9 буюу 64.2% нь Ардчилсан намын гишүүн болон дэмжигчид юм байна. Мөн тэдний дотор газар, хэлтсийн дарга болон орлогч 5 хүн байв.

4. Гаалийн ерөнхий газар.

1996 онд батлагдсан Монгол улсын Гаалийн тухай хуулийн дагуу гаалийн албаны ажилтнууд нь төрийн тусгай албанд харьяалагдаж ажил, албан тушаал эрхэлж байна. Гаалийн хяналтын албаны ажил, албан тушаалын онцлогоос хамаарч тэднийг ажпаас нь өөрчлөх, сэлгэн байршуулах асуудал байнга гардаг байна.

Харин гаалийн байгууллагад аливаа намын харьяалал буюу үзэл бодлоос нь шалтгаалж ажилтныг албан тушаалаас нь чөлөөлж байгаа асуудлын хувьд бол 1996 оны 9 дүгээр сараас 2000 оны 9 дүгээр сар хүртэл Гаалийн ерөнхий газрын удирдлага, мөн газрын төв аппарат болон орон нутгийн салбар, нэгжид удирдах тушаалын ажил эрхэлж байгаа 90 хүнээс 14-ийг албан тушаалаас нь чөлөөлж, оронд нь Монголын ардчилсан намын гишүүн болон дэмжигчийг, 2000 оны 9 дүгээр сараас хойш 15 хүнийг мөн ажлаас нь чөлөөлж, оронд нь МАХН-ын гишүүн болон дэмжигчийг авч ажиллуулжээ. Эдгээр хүмүүсийн ажлаас халсан шалтгааныг өөр газар ажиллах болсон, өөрөө хүсэлт гаргасан гэсэн нь үндэслэл муутай байна. Мэргэжлийн ур чадварын шалгалтанд хангалтгүй үнэлгээ авсан гэж албан тушаалаас нь чөлөөлсөн 10 хүн /гаалийн улсын байцаагч/-ий 9 нь буцаж ажилдаа орсон байна.

Улсын хэмжээнд төрийн албаны мэргэшлийн шалгалтанд орж тэнцсэн хүмүүсийг намын харьяалал буюу итгэл үнэмшил, үзэл бодлоос нь шалтгаалж ажилд аваагүй баримт одоогоор илрээгүй байна.

Иргэний итгэл үнэмшилтэй байх эрхийн хэрэгжилтийн судалгааны явцад тусгайлан Төв аймаг болон Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Санхүү, Эдийн засгийн яамны ажилтнуудын дунд төрийн захиргааны албан хаагчдыг намын харьяаллаас нь шалтгаалж ажлаас халж байгаа эсэх талаар анкетын асуулга явуулав.

Жишээ: Үүнд 65 хүн хамрагдсаны ба тэдний 43 буюу 66.1% нь 1996 оноос хойш улсын хэмжээнд намын харьяаллаас болж төрийн захиргааны албан хаагчдыг олон тоогоор халсан гэдэг шүүмжлэл үндэслэлтэйг, 33 буюу 50.7% нь хүмүүсийг ажлаас халж байгаа шалтгаан нь тухайн албан хаагч өөр намын гишүүн буюу үзэл баримтлалтай байдаг гэснийг тус тус нотолжээ.

ДҮГНЭЛТ

Монгол улс дахь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг хүн бүр сайн дураараа эвлэлдэн нэгдэх, төрийг удирдах хэрэгт оролцох боломжийн хүрээнд бүхэлд нь авч үзвэл, манай иргэд энэ төрлийн эрхийг зохих хэмжээгээр хэвийн эдэлж байгаа дүр төрх байна. Харин иргэн итгэл үнэмшилтэй байх эрхийг аливаа ялгаваргүй буюу хязгаарлалтгүй эдэлж байх гэсэн шууд утгаар Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал болон олон улсын эрх зүйн бусад баримт бичигт заасанчлан үзвэл энэ эрх Монгол улсад тодорхой хэмжээгээр зөрчигдөж байгаа буюу хэрэгжилтийн байдал хэвийн биш гэж үзэж болно. Үүнд:

1. Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 8, 15 дугаар зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3, Прокурорын байгууллагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1, ХҮЭЖ тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтууд Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал болон олон улсын холбогдох гэрээнд заасан зарчим, үзэл санаа, түүнчлэн Монгол улсын Үндсэн хуулийн заалт /16 дугаар зүйлийн 10, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/-д нийцэхгүй байна. Ийнхүү хүний итгэл үнэмшилтэй байх эрх буюу чөлөөт үзэл санааг төрөөс императив хэм хэмжээ тогтоох замаар хязгаарлаж байгаа явдал нь хүмүүс үзэл бодлоор хуваагдан талцах, ялгаварлах, намчирхах буюу улс төржих, шударга бусаар аливаа эрх мэдэл, давуу байдал олж авахыг эрмэлзэх гэх мэт сөрөг үр дагавар үүсгэх, улмаар хүний эрх, эрх чөлөөг зөрчихөд хүргэх хандлагатай байгааг өөрчлөх шаардлагатай байна.

2. 1990-ээд оноос хойшхи хугацаанд төрийн албан хаагчдыг улс төрийн намын харьяаллаас нь шалтгаалан ажпаас өөрчлөх, халах үзэгдэл нийтлэг шинжтэй болжээ. Энэ нь ялангуяа, УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгууль явагдаж аль нэг нам, эвсэл, шинээр засгийн эрх барьж эхэлсэн тухайн жилд буюу түүний дараах эхний жилд нь илүүтэй гарч байдгийг бодит тоо, жишээ баримт харуулж байна. Тусгайлан сонгож судалгаа хийсэн 4 байгууллагаас гөрийн захиргааны албан хаагчид үндсэн нэгжийг нь бүрдүүлдэг Төв аймгийн эолон Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Санхүү, эдийн засгийн яамны хэмжээгээр Ардчилсан холбоо эвсэл сонгуульд ялж засгийн эрх эарьсан 1996 оны сонгуулийн дараа 30 хүн намын харьяаллаар ажлаас эөрчлөгдсөний 28 нь уг сонгуулийн эхний жилүүдэд, мөн эдгээр зайгууллагуудын хувьд МАХН сонгуульд дийлэнхи олонхи болж төр барьж зхэлсэн 2000 оны сонгуулийн дараа 42 хүн намын харьяаллаар өөрчлөгдсөний 28 нь сонгууль явагдсан тухайн жилд ажлаас чөлөөлөгджээ. Үүнийг хүснэгтээр /зүүлбэл:

Байгууллагын нэр	1996 оны сонгуулиар Ардчилсан холбоо эвсэл			2000 оны сонгуулиар МАХН		
	Бүгд	Эхний	Хувь	Бүгд	Тухайн	Хувь

		ЖИЛҮҮДЭД			ЖИЛД	
Төв аймгийн здтг	14	14	100%	15	3	20%
Нийслэлийн БГД-ийн ЗДТГ	16	14	87.5%	18	16	88.8%
Санхүү, эдийн засгийн яам	=	=	-	9	9	100%
Бүгд	30	28	94.2%	42	28	66.6%

Төрийн албан хаагчийг намын харьяалал, үзэл бодлоос нь шалтгаалж ажлаас нь халж, өөрчлөх явдал аль ч нам, эвсэл засгийн эрх барьж буй үед нийтлэг байгаа нь дээрхи байдлаас харагдана. Энэ оны 4-7 дугаар сард хүний эрхийн төлөв байдлын судалгаа явуулсны дараа ирүүлсэн 12 аймгийн тайланд ч энэ талаар дүгнэлт, жишээ баримт дурдсан ажээ. Бидний явуулсан анкетын санал асуулгын дүн үүнийг бас давхар гэрчилж байгаа болно.

Нөгөө талаар удирдах албан тушаалтан /ихэнхдээ улс төрийн/ харьяалалдаа байгаа хүмүүсийг санал бодлоор нь ялгаварлан ажлаас нь өөрчилж байгаа асуудал өөрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхээ хэтрүүлж байгаагийн нэг илрэл мөн.

3. УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгууль явагдаж төр, засгийн эрх барих нам улс төрийн хүчний байр солигдсон үед төр, захиргааны аль ч байгууллагад бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийдэг “муу зуршил” тогтсон байгаа нь төрийн албан хаагчийг ажил албанаас нь халж өөрчлөх нэг арга болж байна. Бидний тусгайлж судалгаа явуулсан 4 байгууллагад бүгдэд нь “бүтцийн өөрчлөлт” хийжээ.

4. Шинжлэх ухаан, технологи хөгжиж салбар бүрт компьютер, цахим техник нэвтэрч байгаа өнөө үед ажлын байр, орон тоо, төсөв, цалингийн сан багасах, ялангуяа, үйлдвэр, аж ахуйн газарт ийм шалтгаанаар ажиллагсдыг бөөнөөр нь халах асуудал гарахыг үгүйсгэхгүй.

5. Көдөлмөрийн тухай хууль (1999 о^гХөдөлмөрийн гэрээУажил олгогчийн санаачилгаар цуцалж болох нэг үндэслэл бол аж ахуйн нэгж, байгууллага болон түүний салбар нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, эсхүл ажилтны тоог цөөрүүлсэн байх явдал гэж үзжээ. Гэтэл төрийн байгууллагыг сонгох сонгууль болсны дараа төсөв, ажлын байр, орон тоо, цалингийн сан өөрчлөгдөөгүй хэвээр байгаа нөхцөлд байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг өөрчилнө гэдэг нь түүнийг боловсронгуй болгох буюу хямдруулах үүднээс биш ажилтныг үзэл бодлоор нь ялгаварлаж халж солих зорилготой байжээ гэж үзэх үндэслэлтэй байна. Энэ байдлыг халагдаж, чөлөөлөгдсөн хүмүүсийн ажлын байранд удирдлагын үзэл баримтлалтай нэгэн адил

үзэл бодолтой хүмүүсийг авч ажиллуулсан дээрхи /судалгаа хийсэн/ байгууллагууд дээр гарсан жишээ, баримтаас харж болно.

6. Иргэний үзэл бодолтой байх эрхийн хэрэгжилтийн талаар явуулсан энэхүү судалгаатай холбогдуулж Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь төрийн дээд өндөрлөгүүдийг зохих мэдээллээр хангах, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа зохих хуулиудад өөрчлөлт оруулах, төрийн захиргааны албаны зөвлөл болон хууль, хяналтын байгууллагатай хамтарч шаардлагатай зарим газар шалгалт хийх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авах тухай саналыг УИХ болон Засгийн газарт ооуулах шааодлагатай юм.

ҮЗҮҮЛТҮҮДИЙН ТАЙЛБАР

1. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний сүүлийн 6 жилийн зарим үзүүлэлтэд байгаа, ТЗАЗ, 2001.11.05.
2. МАХН-ын улс төрийн хэлтсийн 2001.11,07-ны 392 тоотоор ирүүлсэн танилцуулгаас.
3. УИХ-ын гишүүн Ж.Наранцацралт, Л.Гүндалай нараас УИХ-д өргөн барьсан “Улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан, төрийн албан хаагчдыг ажлаас нь халж, өөрчилж байгаа алдаа, завхралыг арилгах тухай” УИХ-ын тогтоолын төслийн танилцуулгаас.
4. Төрийн захиргааны албан хаагчийн эрх зөрчигдсөн тухай өргөдөл /маргаан/-ийг хянан шийдвэрлэсэн тухай судалгаанаас, ТЗАЗ, 1995-1999 оны эхний хагас жилд.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ҮЗЭЛ БОДОЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХТЭЙ ХОЛБОГДСОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХОЛБОГДОХ ЗААЛТУУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

МОНГОЛ УЛСЫН ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЗААЛТУУД	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗААЛТ	ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭРҮҮДИЙН ЗААЛТ
<p>Төрийн албаны тухай хууль 4-р зүйл 2-ын 5 Төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх</p> <p>13-р зүйлийн 8 Төрийн захиргааны албан хаагч нь албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих нийтлэг үүрэг хүлээнэ.</p> <p>15-р зүйлийн 1 Төрийн захиргааны албан хаагч албан үүрэгтэйгээ холбоогүй асуудлаар нам, олон</p>	<p>16-р зүйлийн 10 Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно.</p> <p>16-р зүйлийн 16</p>	<p>Хүний эрхийн Түгээмэл тунхаглал Оршил Итгэл үнэмшилтэй байх нь хүн ардын эрхэм дээд эрмэлзлэл мөн хэмээн үзэж хүний эрхийн энэхүү түгээмэл Тунхаглалыг зарлан 20-р 20- р зүйлийн 2 зүйлийн 1 Хүн бүр тайван замаар сайн дураар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй. тунхаглаж байна. Хэнийг ч аливаа эвлэл холбоонд албадан оруулах ёсгүй. 21- р зүйлийн 2 Хүн бүр улс орондоо төрийн алба хаших тэгш эрхтэй. 23-р зүйлийн 1 Хүн бүр хөдөлмөрлөх, ...хөдөлмөрийн</p>

<p>нийтийн болон шашны байгууллагын үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн хувьд оролцохыг хориглоно.</p> <p>16-р зүйлийн 1</p> <p>Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний захиргааны албан тушаал эрхлэх эрхийг.....нам, олон нийтийн бусад байгууллагын харьяалал зэргээр ялгаварлаж үл болно.</p> <p>17-р зүйлийн 1</p> <p>Төрийн захиргааны албан тушаалын сул орон тооны талаар ажил олгогч нийтэд мэдээлж, иргэдийг сонгон шалгаруулах замаар ажилд авна.</p> <p>Му-ын ХЭҮК-ын тухай хууль</p> <p>21-р зүйлийн 1</p> <p>Комисс, түүний ажлын албанд улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Комиссын гишүүн албан тушаал хаших хугацаандаа улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэнэ.</p> <p><i>МУ-ын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль</i> <i>албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль</i></p>	<p>... итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөтэй</p> <p>16-р зүйлийн 9</p> <p>Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжпан төрийг удирдах хэрэгт төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.</p> <p>19-р зүйлийн 2</p> <p>Онц болон дайны байдал зарласан тохиолдолд ҮХ, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний итгэл үнэмшилтэй байх. Хуулийн заалтыг үл хөндөнө.</p> <p>46-р зүйлийн 2</p> <p>Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандпан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана.</p>	<p>шударга, таатай нөхцөлөөр хангуулах эрхтэй.</p> <p>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт</p> <p>2-р зүйлийн 1</p> <p>Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ эрх мэдэлдээ байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг улс төрийн болон бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй.</p> <p>25-р зүйлийн “С”</p> <p>Иргэн бүр ... тэгш эрхийн нийтлэг нөхцөлтэйгөөр улсдаа төрийн алба хаах эрх чөлөө ба боломжийг ямар нэг үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр эдэлнэ.</p> <p>Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт</p> <p>2-р зүйлийн 2</p> <p>Энэхүү Пактад оролцогч улсууд улс төрийн буюу ... бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр энэхүү Пактад тунхаглан зарласан эрхийг хэрэгжүүлэх баталгаа гаргах үүрэгтэй.</p> <p>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт</p> <p>7-р зүйлийн 1</p> <p>Энэхүү Пактад оролцогч хүн бүр шударга, аятай таатай хөдөлмөрийн нөхцөлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрнө</p>
---	--	---

МОНГОЛ УЛСЫН ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЗААЛТУУД

29-р зүйлийн 1

Цэргийн албан хаагч цэргийн албаны үүргийн онцлог, түүнд тавих шаардлагаас үндэслэн улс төрийн зорилгоор эвлэлдэн нэгдэх, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг эвсэл, холбооны гишүүн байхыг

хориглоно.

Монгол улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хууль

3-р зүйлийн 5

Цэцийн гишүүн засаг захиргаа, нам-улс төрийн болон худалдааны үйл ажиллагаа эрхэлж, үйлдвэрчний эвлэлийн удирдах ажил хийж болохгүй.

Дипломат албаны тухай хууль

11-р зүйлийн 1-ийн 2

Дипломат ажилтан нь дипломат алба хаах хугацаандаа улс төрийн аливаа нам, хөдөлгөөний гишүүн байх, үйл ажиллагаанд нь аль нэг хэлбэрээр оролцохоос түдгэлзэх үүрэгтэй.

Улс төрийн намуудын тухай хууль

2-р зүйл

18 насанд хүрсэн иргэд сайн дураар эвлэлдэн нэгдэж нам байгуулж болно.

3-р зүйл

Нам, түүний гишүүдийг үзэл бодолтой нь холбогдуулан мөшгөн хавчих, заналхийлэх, гүтгэх, доромжлох явдлыг хориглоно.

4¹-р зүйл

Төрийн албан хаагч албан тушаалын үүрэг гүйцэтгэхдээ аль нэг намын эрх ашгийн үүднээс бус гагцхүү улсын эрх ашгийн үүднээс хандаж эрх зүйн хэм хэмжээнд захирагдан ажиллана.

Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хууль

1-р зүйл

Төрийн дор дурдсан албан тушаалд сонгууль болон томилолтоор ажиллаж байгаа улс төрийн аль нэгэн намын гишүүн, МУ-ын иргэн уг албан тушаалд байх хугацаандаа намын гишүүнээсээ түдгэлзэнэ.

1. Монгол улсын Ерөнхийлөгч
2. Бүх шатны шүүхийн дарга, оролгогч дарга, гишүүн, шүүгч
3. Бүх шатны прокурор мөрдөн байцаагч
4. МУ-ын Зэвсэгт хүчин, Пагтаагийн болон УАБХ. Засан хэмжээг үндэслэн байгууллагын байнгын бие бүрэлдэхүүний бүх албан хаагч
5. МУ-ын галаал харилцааны дипломат ажилтан
6. УИХ-ын лэргэлэх Сонгвлийн ерөнхий хорооны дарга, нбд, гишүүн, ажилтан
7. ҮХИ-ийн дарга, гишүүн, ажилтан
8. ХЭҮК-ын гишүүн

2-р зүйл

Дээрхи албан тушаалд ажиллахаар нэр дэвшсэн буюу хүсэлтээ илэрхийлсэн иргэн улс төрийн аль нэг намын гишүүн бол уг албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон нөхцөлд намын гишүүнээс түдгэлзүүлсэн эсэхээ зохих шийдвэр гарахын өмнө илэрхийлсэн байвал зохино. Харин уг иргэн зохих албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 7 хоногийн дотор намын гишүүнээс түдгэлзсэнээ албан ёсоор мэдэгдэнэ.

Монгол Улсын Шүүхийн тухай хууль

6-р зүйлийн 3

Шүүх, шүүхийн байгууллагад улс төрийн нам, эвсэл, холбоо, хөдөлгөөний үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Шүүгчийн албан тушаал хаших хугацаанд түүний улс төрийн намын гишүүнчлэлийг түдгэлзүүлнэ.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль

36-р зүйлийн 1

Цагдаагийн албан хаагч улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулдаг эсвэл, холбооны гишүүн байх, цагдаагийн бие бүрэлдэнхүүний дотор аль нэг нам, эвсэл, холбооны улс төрийн үзэл баримтлалыг сурталчлахыг хориглоно.

36-р зүйлийн 2

Цагдаагийн албан хаагч ... эвлэлдэн нэгдэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй

хандана.

Прокурорын байгууллагын тухай хууль

29-р зүйлийн 1

Прокурорын байгууллагад улс төрийн нам, холбоо, эвсэл, хөдөлгөөний үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Хөдөлмөрийн тухай хууль

7 дугаар зүйлээс

7.2 Хөдөлмөрийн харилцаанд үзэл бодпоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно.